**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2025 оны 01 дүгээр сарын 20 Дугаар: БА-018/2025 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын Нийслэлийн Баянзүрх дүүргийн 6, 15, 18, 25 дугаар хороонд Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат шинэчлэх багц-2 ажил, дунд төвөгшилтэй ангиллын 12 ширхэг цахилгаан шатны угсралт, шинэчлэлтийн ажилд Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний огноо, дугаар: Байхгүй.

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр, дугаар: Байхгүй.

2.3. Захиалагч: Улаанбаатар лифт НӨҮГ, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9014001068, регистрийн дугаар: 5584388, хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 15 дугаар хороо, 13 дугаар хороолол, Намьянжугийн гудамж, 5 дугаар байрны зүүн талд өөрийн байр, холбоо барих утас: 70162680

2.4. Барилга байгууламжийн ажлын гүйцэтгэгч байгууллага: Оакс Экспресс Монголиа ХХК, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 000243508, регистрийн дугаар: 5355699, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар: ӨБ18-147/23, хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 5 дугаар хороо, П.Н.Шастины нэрэмжит 3 дугаар эмнэлгийн замын урд 5 давхар барилга, 401 тоот, холбоо барих утас: 99108908, 99069677

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч: Байхгүй.

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Байхгүй.

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Асар СӨХ, хаяг: Баянзүрх дүүргийн 6 дугаар хорооны 22Б байрны 5 дугаар орц, 21 дүгээр байрны 3 дугаар орц, холбоо барих утас: 88192509,

Чандмана СӨХ, хаяг: Баянзүрх дүүргийн 6 дугаар хорооны 5 дугаар байрны 5 дугаар орц, 4 дүгээр байрны 3 дугаар орц, холбоо барих утас: 88134313,

Мандах 2 СӨХ, хаяг: Баянзүрх дүүргийн 18 дугаар хорооны 22А дугаар байрны 2 дугаар орц, 14 дүгээр байрны 3 дугаар орц, холбоо барих утас: 88343123,

Сэлбэ СӨХ, хаяг: Баянзүрх дүүргийн 18 дугаар хорооны 11 дүгээр байрны 3 дугаар орц, холбоо барих утас: 94114740,

Хос өргөө СӨХ, хаяг: Баянзүрх дүүргийн 18 дугаар хорооны 13 дугаар байрны 3 дугаар орц, холбоо барих утас: 90910309,

Ганга СӨХ, хаяг: Баянзүрх дүүргийн 18 дугаар хорооны 38 дугаар байрны 1 дүгээр орц, холбоо барих утас: 90970905,

Өндөр 39 СӨХ, хаяг: Баянзүрх дүүргийн 18 дугаар хорооны 39 дүгээр байрны 1 дүгээр орц, холбоо барих утас: 90811212,

Говь СӨХ, хаяг: Баянзүрх дүүргийн 25 дугаар хорооны 36Б байр, 37 дугаар байр, холбоо барих утас: 94998845,

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

☐ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгатай НЗДТГ/20240101003/01/01 тоот гэрээний дугаартай Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх багц-2 ажил (Баянзүрх дүүргийн 18 дугаар хорооны 38 дугаар байрны 1 дүгээр орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 8 зогсоолтой, 25 дугаар хорооны 36Б дугаар байранд 1 м/с хурдтай 400кг даацтай 8 зогсоолтой, 25 дугаар хорооны 37 дугаар байранд 1 м/с хурдтай 400кг даацтай 8 зогсоолтой, 6 дугаар хорооны 22Б дугаар байрны 5 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 6 дугаар хорооны 21 дүгээр байрны 3 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 15 дугаар хорооны 5 дугаар байрны 5 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 15 дугаар хорооны 4 дүгээр байрны 3 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 18 дугаар

хорооны 22А дугаар байрны 2 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 18 дугаар хорооны 14 дүгээр байрны 3 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 18 дугаар хорооны 11 дүгээр байрны 3 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 18 дугаар хорооны 13 дугаар байрны 3 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 18 дугаар хорооны 39 дүгээр байр 1 дүгээр орцонд 1 м/с хурдтай 630кг даацтай 12 зогсоолтой) дунд төвөгшилтэй ангиллын 12 ширхэг цахилгаан шатны угсралт, шинэчлэлтийн ажилд холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ цахилгаан шатны угсралт, шинэчлэлтийн ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) Барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а) Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) Барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) Барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 4 хуудас, хуралдааны тэмдэглэл 4 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс

## Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Баянзүрх дүүргийн 6, 15, 18, 25 дугаар хороонд Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат шинэчлэх багц-2 ажил, (Баянзүрх дүүргийн 18 дугаар хорооны 38 дугаар байрны 1 дүгээр орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 8 зогсоолтой, 25 дугаар хорооны 36Б дугаар байранд 1 м/с хурдтай 400кг даацтай 8 зогсоолтой, 25 дугаар хорооны 37 дугаар байранд 1 м/с хурдтай 400кг даацтай 8 зогсоолтой, 6 дугаар хорооны 22Б дугаар байрны 5 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 6 дугаар хорооны 21 дүгээр байрны 3 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 15 дугаар хорооны 5 дугаар байрны 5 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 15 дугаар хорооны 4 дүгээр

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

байрны 3 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 18 дугаар хорооны 22А дугаар байрны 2 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 18 дугаар хорооны 14 дүгээр байрны 3 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 18 дугаар хорооны 11 дүгээр байрны 3 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 18 дугаар хорооны 13 дугаар байрны 3 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 18 дугаар хорооны 39 дүгээр байр 1 дүгээр орцонд 1 м/с хурдтай 630кг даацтай 12 зогсоолтой) дунд төвөгшилтэй ангиллын 12 ширхэг цахилгаан шатны угсралт, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгатай,
Баянзүрх дүүргийн 6, 15, 18, 25 дугаар хороо,
Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат шинэчлэх ажил

Комиссын дарга:
Нийслэлийн Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Мөнгөн)

9024047846
8314551 БТ24866

Нарийн бичгийн дарга:
Улаанбаатар лифт НӨҮГ-ын
Ерөнхий инженер (М.Энхбат)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын
үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭВ.
Объектын дугаар: 850
Огноо: 2025 он 01 сар 20 өдөр
Бүртгэсэн: О. Жим
УЛААНБААТАР ХОТ ТТМ 1584

ЦАХИЛГААН ШАТНЫ УГСРАЛТ, ШИНЭЧЛЭЛТИЙН АЖЛЫГ БАЙНГЫН АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 26 Улаанбаатар хот

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгатай НЗДТГ/20240101003/01/01 тоот гэрээний дугаартай Баянзүрх дүүргийн 6, 15, 18, 25 дугаар хороонд Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат шинэчлэх Багц-2 ажил, дунд төвөгшилтэй ангиллын 12 ширхэг цахилгаан шатны угсралт, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр 09:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 17:00 цагт дуусав.

Хуралд:

1. Комиссын дарга:
   Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч — Б.Батчимэг
2. Комиссын нарийн бичгийн дарга:
   Улаанбаатар Лифт НӨҮГ-ын ерөнхий инженерийн албан тушаалыг түр хавсран гүйцэтгэгч хяналтын инженер — Ц.Уранбилэг

Комиссын гишүүд:

3. Хяналт шалгалтын газрын
   Барилгын техникийн хяналтын Улсын байцаагч — Н.Чимэдрэгзэн
4. Барилгын хөгжлийн төвийн
   Норм, нормативын хэлтсийн мэргэжилтэн — Г.Уртнасан
5. Үндэсний төв Архивын Архивч — Н.Өлзийжаргал
6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгууллагын төлөөлөл — Н.Эрдэнэтөгс
7. Ашиглагч байгууллага:
   - Говь СӨХ-ны гүйцэтгэх захирал — Л.Сүх-Эрдэнэ
   - Өндөр 39 СӨХ-ны гүйцэтгэх захирал — Х.Болорцэцэг
   - Мандах 2 СӨХ-ны гүйцэтгэх захирал — Ш.Чингэрэл
   - Сэлбэ СӨХ-ны гүйцэтгэх захирал — Ч.Энхтуяа
   - Асар СӨХ-ны гүйцэтгэх захирал — Т.Оюунгэрэл
   - Ганга СӨХ-ны гүйцэтгэх захирал — Б.Ундармаа
   - Чандмана СӨХ-ны гүйцэтгэх захирал — Ц.Цэцэгмаа
   - Хос өргөө СӨХ-ны гүйцэтгэх захирал — П.Нарангэрэл
8. Гүйцэтгэгч байгууллага:
   Оакс экспресс монголиа ХХК-ийн гүйцэтгэх захирал — Ц.Энхжин

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгатай НЗДТГ/20240101003/01/01 тоот гэрээний дугаартай Баянзүрх дүүргийн 6, 15, 18, 25

дугаар хороонд Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат шинэчлэх Багц-2 ажил, дунд төвөгшилтэй ангиллын 12 ширхэг цахилгаан шатны угсралт, шинэчлэлтийн ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд цахилгаан шатны ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Комиссын дарга: Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Б.Батчимэг**

- Барилгын тухай хуулийн 14.3, 14.6-н дагуу чанарын баталгаа гаргах. Хяналт шалгалтын газарт
- Ашиглагчтай ажлын тоо хэмжээг актаар хүлээлцэх.
- Техникийн өрөөний заслын ажлын хог хаягдлыг буулгах (1 орц)
- Техникийн өрөөний засал хийсэн фото зураг өмнө, дараа байдлаар актад оруулах. Дутуу засал хийгдээгүйг гүйцээх.
- СӨХ-үүдээс тодорхойлолт авах (8 ш)

Комиссын нарийн бичгийн дарга: Улаанбаатар лифт НӨҮГ-ын ерөнхий инженерийн албан үүргийг түр хавсран гүйцэтгэгч хяналтын инженер **Ц.Уранбилэг**

- Лифтнүүдийн техникийн өрөөний заслын ажлыг дахин хийх.
- 4, 5, 14, 22А байруудын моторын суурийн хашлага хийх.
- 14, 22А байрны хонгилын хаалганы гуяны бэхэлгээг хийх.
- Лифтнүүдийн санамж байршуулах.
- Лифтнүүдийн даац тохируулах.
- 39 дүгээр байрны 4, 5-н давхрын босгыг тэргэнцэртэй иргэнд зориулж налуу болгох.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилгын техникийн хяналтын Улсын байцаагч **Н.Чимэдрэгзэн**

- Нийт лифтний хувьд машины өрөөнд хуучин лифтний эд ангиудыг өрөөнөөс гаргах.
- Зориулалтын бус цахилгааны кабель болон холбооны төхөөрөмжийг гаргах.
- Цонх шиллэж битүүлэх, хаалганы бат бөх найдвартай байдлыг хангаж засварлах, шинэчлэх (36Б, 37)
- Машины өрөөнд галын хор байрлуулах.
- Машины өрөөний эргүүлэг байрлах тавцанд хаалт хашилт гүйцээх.
- 4 дүгээр байр 3 дугаар орц – Туслах шкив тэгш суурилуулах, эсрэг ачааны даравч хийх.
- 5 дугаар байр 5 дугаар орц – Туслах шкив тэгш суурилуулах, 6 дугаар давхрын хонгилын хаалганы башмак боолт дутуу хийсэн.
- 11 дүгээр байр 3 дугаар орц – Ган татлагын нүхний хаалт хийх, ган татлага шүргэж байгаа хэсгийг засварлах, босгоны хаалт хийх.
- 22 дугаар байр 2 дугаар орц – Хонгилын хаалганы бэхэлгээ хийх.
- 14 дүгээр байр 3 дугаар орц – Хонгилын хаалганы бэхэлгээ хийх.
- 39 дүгээр байр – Машины өрөөнд гэрэлтүүлэг нэмэх.
- 38 дугаар байр 1 дүгээр орц – Эсрэг ачаа башмак солих.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авах.

Барилгын хөгжлийн төвийн Норм, нормативын хэлтсийн мэргэжилтэн **Г.Уртнасан**

- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасан норм, нормативын сангийн төлбөр төлөх.

Үндэсний төв архивын Зураг төслийн баримтын архивын архивч **Н.Өлзийжаргал**

- Гүйцэтгэлийн баримт бичигт жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй бүрдүүлэх, хуудас дугаарлаж, дотоод товъёог үйлдэх.
- Баримт бичгийн эх хувийг архивд хүлээлгэн өгөх.

“Говь” сууц өмчлөгчдийн холбооны гүйцэтгэх захирал **Л.Сүх-Эрдэнэ**

- Гэрээнд заасан 4.6-д зааснаар лифт эвдрэх үед хэдий хугацаанд засах хугацааг тодорхой болгох.
- Лифтний техникийн өрөөний гэрлийн шитийг асааж унтраах хэрэглэлтэй болгох.
- Тус 2 байрны лифтийг хариуцан ажиллах Оакс компани хэдий хугацаанд хяналт тавих, засвар үйлчилгээг яаж хийх хугацааг тодорхой болгож өгнө үү.
- Оакс компани хэдий хугацаанд хариуцан ажиллах цаг хугацааг хэлэх.
- Дараа нь УБ лифт НӨҮГ авна гэдгийг тодруулж өгнө үү.

“Өндөр 39” сууц өмчлөгчдийн холбооны гүйцэтгэх захирал: **Х.Болорцэцэг**

- Чанарын баталгаа гаргаж өгөх.
- Лифтний босго янзлах /тэргэнцэртэй хүн орох, гарахад чөлөөтэй байх/
- Лифтний техникийн өрөөг будах.
- Ашиглалтад орж буй лифтний цахилгааны тэжээлийн утсыг шийдвэрлэх.
- Дээврийн хөндийд цоолсон 2 нүхийг бөглөх.

“Мандах 2” сууц өмчлөгчдийн холбооны гүйцэтгэх захирал **Ш.Чингэрэл**

- 22А байрны 2 дугаар орцны лифтэнд хогийн функерийн хана цоолсон нүхийг бөглөх, 7, 8, 9 давхарт хонгилын хаалганы бэхэлгээг засах, техникийн өрөөний заслын ажлыг бүрэн хийж гүйцэтгэх.
- 14 дүгээр байрны 3 дугаар орцонд хонгилын хаалганы бэхэлгээг засварлах.

“Сэлбэ” сууц өмчлөгчдийн холбооны гүйцэтгэх захирал **Ч.Энхтуяа**

- Үүрэг даалгаврын биелэлтээр, угсрагдсан 11 дүгээр байрны 3 дугаар орцны лифтийг ажиллуулах хүсэлтэй байна.
- Кабин дотор санамж байрлуулах.

“Асар” сууц өмчлөгчдийн холбооны гүйцэтгэх захирал **Т.Оюунгэрэл**

- Заслын ажил хийх.
- Лифтээ хурдан ашиглалтад оруулах хүсэлтэй байна.

“Ганга” сууц өмчлөгчдийн холбооны гүйцэтгэх захирал **Б.Ундармаа**

- Будаг нэг өнгө болгох, цоолсон ханыг битүүлээд нэг өнгөөр будах.

“Чандмана” сууц өмчлөгчдийн холбооны гүйцэтгэх захирал **Ц.Цэцэгмаа**

- 5 дугаар байрны 5 дугаар орцны машины өрөө засуулах.
- Лифтийг хурдан ашиглалтад оруулах хүсэлтэй байна.

“Хос өргөө” сууц өмчлөгчдийн холбооны гүйцэтгэх захирал **П.Нарангэрэл**

- Лифтийг хурдан ашиглалтад оруулах хүсэлтэй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгууллагын төлөөлөл **Н.Эрдэнэтөгс**

- 15 дугаар байрны 3 дугаар орцны 1 давхрын шалны блентусыг лифтний амлагаатай чацуулж хийх.
- 39 дүгээр байрны 4 давхрын лифт рүү орох хэсгийн босгыг налуу болгох шаардлагатай.
- 36Б байрны лифтний орох гарах хэсгийн шатны догол арилгах (4 давхарт)
- 37 дугаар байрны 1, 2, 4, 5, 6, 8, 9 давхрын лифтнээс орох, гарах хэсгийн налуулга огцом байна (хэт). Налуулгыг стандартад нийцүүлэх шаардлагатай байна.

Гүйцэтгэгч байгууллага: Оакс экспресс монголиа ХХК-ийн захирал **Ц.Энхжин**

- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах хүсэлтэй байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгатай НЗДТГ/20240101003/01/01 тоот гэрээний дугаартай Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх Багц-2 ажил (Баянзүрх дүүргийн 18 дугаар хорооны 38 дугаар байрны 1 дүгээр орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 8 зогсоолтой, 25 дугаар хорооны 36Б дугаар байранд 1 м/с хурдтай 400кг даацтай 8 зогсоолтой, 25 дугаар хорооны 37 дугаар байранд 1 м/с хурдтай 400кг даацтай 8 зогсоолтой, 6 дугаар хорооны 22Б дугаар байрны 5 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 6 дугаар хорооны 21 дүгээр байрны 3 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 15 дугаар хорооны 5 дугаар байрны 5 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 15 дугаар хорооны 4 дүгээр байрны 3 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 18 дугаар хорооны 22А дугаар байрны 2 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 18 дугаар хорооны 14 дүгээр байрны 3 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 18 дугаар хорооны 11 дүгээр байрны 3 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 18 дугаар хорооны 13 дугаар байрны 3 дугаар орцонд 1 м/с хурдтай 400кг даацтай 9 зогсоолтой, 18 дугаар хорооны 39 дүгээр байр 1 дүгээр орцонд 1 м/с хурдтай 630кг даацтай 12 зогсоолтой) дунд төвөгшилтэй ангиллын 12 ширхэг цахилгаан шатны угсралт, шинэчлэлтийн ажлыг комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:
Нийслэлийн Хяналт шалгалтын газрын,
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батчимэг)

Тэмдэглэл хөтөлсөн:
Улаанбаатар лифт НӨҮГ-ын
Ерөнхий инженер (М.Энхбат)